

НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Нийслэлийн Өмчийн харилцааны газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: НТАГ-2025/419/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Улаанбаатар хот
2025 он

Нийслэл дэх Төрийн аудитын газрын дэд дарга: Ч.Болд
Утас: 7000-7734 Цахим хаяг: boldch@audit.gov.mn

Санхүү, нийцлийн аудитын хэлтсийн дарга: Х.Түвшинбаяр
Утас: 315558 Цахим хаяг: tuvshinbayarkh@audit.gov.mn

Аудитын менежер: Д.Отгонбаяр
Утас: 315558 Цахим хаяг: otgonbayarda@audit.gov.mn

Аудитор: Э.Ундармаа
Утас: 325093 Цахим хаяг: undarmaae@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1.Хараат бус аудиторын дүгнэлт.....	2
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	2
3. Санхүүгийн тайлангийн тодруулга	13
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	13
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	13
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	14
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд	14
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	15
4. Аудитын тайлан.....	17
4.1 Ерөнхий зүйл.....	17
4.2 Материаллаг байдал	17
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	17
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	17
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	19
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	19
5. Аудитын илрүүлэлт	20
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл	24

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
НТАГ	Нийслэл дэх Төрийн аудитын газар
НӨХГ	Нийслэлийн Өмчийн харилцааны газар
НА	Нотлох ажил
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит, аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ТШЗ	Төсвийн шууд захирагч
УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас:7000 7734, Факс: (976-11) 32 01 54
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2025, 02. 25 № 01/185
танай _____-ны № _____-т

НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН
ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
В.ОЮУМАА ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Нийслэлийн Өмчийн харилцааны газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Нийслэлийн Өмчийн харилцааны газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Төсвийн шууд захирагчийн 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 1,447,254.1 мянган төгрөгийн залруулаагүй алдаа, зөрчил илэрсэн нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс хэтэрсэн бөгөөд УСНББОУС болон холбогдох хууль, журамд нийцээгүй, санхүүгийн тайлангийн "Нийцсэн бөгөөд зохистой байх", "Иж бүрэн байх", "Оршин байх", "Эрх ба үүрэг" батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Нийслэлийн Засаг даргын 2023-2024 оны эрх шилжүүлсэн захирамжаар нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалт бүхий нийт 3 ажилд захиалагчийн хяналт хийж, 120,355.0 мянган төгрөгийн санхүүжилтийг олгосон.

Аудитын гол асуудал

Бэлтгэн нийлүүлэгч байгууллагуудтай хийсэн гэрээний үүргээ биелүүлж, баталгаат хугацаанд хэвийн ашиглаж байгаа тухай ашиглагч байгууллагын хүсэлтийг үндэслэн 5 хувийн барьцаа хөрөнгө 20,680.2 мянган төгрөгийг чөлөөлсөн байна.

Бусад асуудал

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 6 зорилтын хүрээнд 58 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснийг 100.0 хувийн хэрэгжилттэйгээр тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



М.ЭРДЭНЭЖАРГАЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	2,390,138,177.56	2,264,645,421.21
31	МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ	1,037,015,151.06	1,015,503,759.06
312	Банканд байгаа бэлэн мөнгө	1,037,015,151.06	1,015,503,759.06
3121	Төгрөг	1,037,015,151.06	1,015,503,759.06
31213	Арилжааны банкин дахь харилцах	200.00	-
31214	Бусад төсөл нөөцийн харилцах	1,037,014,951.06	1,015,503,759.06
33	АВЛАГА	1,311,178,684.50	1,202,957,041.15
33100	Ажиллагсадтай холбогдсон авлага	3,920,000.00	4,187,600.00
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	367,915,309.15	348,159,595.15
33300	Татаас санхүүжилтийн авлага	81,477,000.00	-
335	Бусад авлага	857,866,375.35	850,609,846.00
3351	Байгууллагаас авах авлага	5,956,529.35	-
3352	Хувь хүмүүсээс авах авлага	851,909,846.00	850,609,846.00
35	БАРАА МАТЕРИАЛ	41,944,342.00	46,184,621.00
354	Хангамжийн материал	41,944,342.00	46,184,621.00
35410	Бичиг хэргийн материал	7,523,624.00	8,486,815.00
35420	Аж ахуйн материал	2,764,546.00	2,331,973.00
35430	Сэлбэг хэрэгсэл	-	20,000.00
35440	Түлш шатах тослох материал	3,140,000.00	920,000.00
35470	Бусад хангамжийн материал	28,516,172.00	34,425,833.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	21,142,804,638.23	20,760,310,763.45
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	21,142,804,638.23	20,760,310,763.45
392	Биет хөрөнгө	20,933,088,798.23	20,559,094,923.45
39201	Барилга, байгууламж	26,160,493,103.33	26,188,882,018.33
39202	Хуримтлагдсан элэгдэл	(5,534,712,190.82)	(6,311,876,108.18)
39203	Авто тээврийн хэрэгсэл	174,617,425.00	143,235,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(108,618,247.34)	(101,650,822.42)
39205	Машин, тоног төхөөрөмж	444,181,116.31	807,384,491.20
39206	Хуримтлагдсан элэгдэл	(379,560,767.47)	(424,174,716.54)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	100,909,138.03	147,999,113.89
39208	Хуримтлагдсан элэгдэл	(74,432,336.60)	(38,175,346.66)
39213	Нийтийн эзэмшил	33,990,768.58	33,990,768.58
39217	Хуримтлагдсан элэгдэл /Нийтийн/	(25,100,890.79)	(27,841,154.75)
39214	Бусад үндсэн хөрөнгө	738,732,206.00	738,732,206.00
39215	Хуримтлагдсан элэгдэл /Нийслэлийн өмчит оруулсан хөрөнгө оруулалт/	(597,410,526.00)	(597,410,526.00)
393	Биет бус хөрөнгө	209,715,840.00	201,215,840.00
39301	Программ хангамж	9,952,000.00	9,952,000.00
39302	Хасагдуулаг	(1,452,000.00)	(9,952,000.00)

Нийслэлийн Өмчийн харилцааны газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

39303	Бусад биет бус хөрөнгө	201,215,840.00	201,215,840.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	23,532,942,815.79	23,024,956,184.66
4	НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	240,937,153,911.74	107,703,443,380.13
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	40,824,188,565.82	145,013,570.74
412	Богино хугацаат зээлийн өглөг	40,534,332,196.08	128,345,094.06
4121	Төгрөг	6,058,109,534.56	128,345,094.06
41214	Төрийн өмчид аж ахуй нэгжүүдийн зээл	5,906,953,248.50	-
41217	Санхүүгийн бусад байгууллага	151,156,286.06	128,345,094.06
4122	Гадаад валют	34,476,222,661.52	-
41224	Төслийн зээл	34,476,222,661.52	-
413	Өглөг	289,856,369.74	16,668,476.68
41310	Ажиллагчидтай холбогдсон өглөг	6,236,369.74	8,716,296.68
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	-	32,180.00
4136	Бусад өглөг	283,620,000.00	7,920,000.00
41361	Байгууллагад төлөх өглөг	283,620,000.00	7,920,000.00
42	УРТ ХУГАЦААТ ӨР, ТӨЛБӨР	200,112,965,345.92	107,558,429,809.39
422	Урт хугацаат зээл	200,112,965,345.92	107,558,429,809.39
4221	Төгрөг	200,112,965,345.92	107,558,429,809.39
42214	Төрийн өмчид аж ахуй нэгжүүдийн зээл	200,011,643,665.92	107,457,108,129.39
42216	Нийслэлийн өмчит оруулсан хөрөнгө оруулалт	101,321,680.00	101,321,680.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	(217,404,211,095.95)	(84,678,487,195.47)
51	Засгийн газрын хувь оролцоо	(217,404,211,095.95)	(84,678,487,195.47)
511	Засгийн газрын оруулсан капитал орон нутгийн сан	21,484,417,253.54	21,484,417,253.54
51101	Өмч: -Төрийн өмч	21,484,417,253.54	21,484,417,253.54
512	Хуримтлагдсан үр дүн	(249,614,304,476.32)	(116,888,580,575.84)
51210	Өмнөх үеийн үр дүн	(248,390,496,240.14)	(116,497,874,829.77)
51220	Тайлант үеийн үр дүн	(1,223,808,236.18)	(390,705,746.07)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	10,725,676,126.83	10,725,676,126.83
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	23,532,942,815.79	23,024,956,184.66

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	68,011,724,398.41	7,784,519,136.70
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	3,327,258,990.43	690,320,566.72
120	Нийтлэг татварын бус орлого	3,327,258,990.43	690,320,566.72
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	213,944,420.83	690,320,566.72
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	9,917,041.98	-
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	8,735,401.00	17,914,073.37
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	195,291,977.85	672,406,493.35
120005	Түрээсийн орлого	3,113,314,569.60	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	64,684,465,407.98	7,094,198,569.98
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	49,610,688,000.00	5,100,573,300.00
131104	Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагч	49,610,688,000.00	5,100,573,300.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	1,473,816,307.98	1,871,535,269.98
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	1,473,816,307.98	1,871,535,269.98
1330	Төсвийн захирагчдаас	13,599,961,100.00	122,090,000.00
133003	Хөрөнгийн	13,599,961,100.00	122,090,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)	68,734,063,435.21	8,011,191,435.87
21	УРСГАЛ ЗАРДАЛ	47,245,386,785.21	6,089,101,435.87
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	22,111,638,581.81	3,653,658,355.80
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	1,116,161,256.18	1,280,276,854.14
210101	Цалин	693,859,541.07	723,219,476.72
210102	Нэмэгдэл цалин	169,904,856.93	238,539,126.42
210103	Унаа хоолны хөнгөлөлт	110,330,851.77	215,731,978.00
210104	Урамшуулал	142,066,006.41	102,786,273.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	142,646,164.33	162,779,785.33
210201	Тэтгэврийн даатгалын шимтгэл	97,546,001.77	112,337,049.22
210202	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	11,488,572.86	13,198,780.87
210203	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	8,975,258.41	6,755,506.43
210204	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	2,241,567.75	5,830,061.53
210205	Эрүүл мэндийн даатгалын хураамж	22,394,763.54	24,658,387.28
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	30,231,867.07	30,464,754.65
210301	Гэрэл цахилгааны зардал	28,554,290.03	28,077,716.92
210303	Цэвэр, бохир усны зардал	-	2,387,037.73
210304	Байрны түрээс	1,677,577.04	-
2104	Хангамж, бараа материалын зардал	51,916,011.56	94,224,206.08
210401	Бичиг хэргийн материал	15,028,553.00	18,848,588.00
210402	Тээвэр, шатахууны зардал	19,701,000.00	38,830,300.00
210403	Шуудан холбоо интернэтийн төлбөр	15,157,458.56	14,960,576.08
210406	Бага үнэ түргэн элэгдэл зүйлс	2,029,000.00	10,791,777.00

Нийслэлийн Өмчийн харилцааны газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	-	2,542,500.00
210408	Бараа материал акталсны зардал	-	8,250,465.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	705,900.00	67,100,000.00
210601	Багаж хэрэгсэл	-	3,090,000.00
210604	Урсгал засвар	705,900.00	64,010,000.00
2107	Томилолт, зочны зардал	-	5,400,000.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	-	5,400,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж	18,637,355,196.52	168,963,516.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	18,621,239,000.00	141,070,200.00
210803	Даатгалын үйлчилгээний төлбөр	588,060.00	534,060.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	315,912.00	315,912.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	160,000.00	130,000.00
210806	Мэдээллийн технологийн үйлчилгээний хөлс	49,000.00	-
210807	Газрын төлбөр	14,738,204.52	24,392,114.00
210809	Улсын мэдээллийн маягтын зардал	265,020.00	2,521,230.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,132,622,186.15	1,844,449,239.60
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,118,507,624.00	942,027,375.37
210902	Хичээл сургалт, үйлдвэрлэлийн дадлагын зардал	2,510,000.00	2,800,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	1,011,604,562.15	899,621,864.23
211	ХҮҮ	9,548,294,100.00	2,362,247,000.00
2112	Дотоод зээлийн үйлчилгээний төлбөр	9,548,294,100.00	2,362,247,000.00
211201	Дотоод зээлийн үйлчилгээний төлбөр	9,548,294,100.00	2,362,247,000.00
212	ТАТААС	15,521,690,675.10	-
2121	Төрийн өмчит байгууллагад олгох татаас	15,521,690,675.10	-
212101	Төрийн өмчит байгууллагад олгох татаас	12,400,000,000.00	-
212102	Нийслэлийн төсөвт төвлөрүүлсэн	3,121,690,675.10	-
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	63,763,428.30	73,296,080.07
2132	Бусад урсгал шилжүүлэг	62,990,453.30	54,500,262.44
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	50,847,497.30	20,592,022.44
213209	Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал	12,142,956.00	33,908,240.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	772,975.00	18,795,817.63
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	272,100.00	18,673,200.00
213405	Төвлөрүүлэх шилжүүлэг нэмэлт санхүүжилт	500,875.00	122,617.63
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	21,488,676,650.00	1,922,090,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	21,488,676,650.00	1,922,090,000.00
220001	Барилга байгууламж	132,704,550.00	-
223001	Бусад хөрөнгө	8,012,000,000.00	1,800,000,000.00
225012	Хөрөнгө оруулалтаар бэлтгэгдсэн шилжүүлэх зориулалттай хөрөнгийн зардал	13,343,972,100.00	122,090,000.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III=I-II)	(722,339,036.80)	(226,672,299.17)
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН (V)	501,469,199.38	164,033,446.90
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	501,469,199.38	164,033,446.90
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VI=IV-V)	(501,469,199.38)	(164,033,446.90)
5	НИЙТ ҮР ДҮН (VII=III+VI)	(1,223,808,236.18)	(390,705,746.07)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	54,561,818,905.84	8,617,031,911.07
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	3,221,325,597.86	1,522,733,341.09
120	Нийтлэг татварын бус орлого	3,221,325,597.86	1,522,733,341.09
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	9,917,041.98	-
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	1,522,733,341.09
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	9,917,041.98	1,522,733,341.09
120005	Түрээсийн орлого	3,211,408,555.88	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	51,340,493,307.98	7,094,298,569.98
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	49,610,688,000.00	5,100,673,300.00
131104	Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захи	49,610,688,000.00	5,100,673,300.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	1,473,816,307.98	1,871,535,269.98
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	1,473,816,307.98	1,871,535,269.98
1330	Төсвийн захирагчдаас	255,989,000.00	122,090,000.00
133003	Хөрөнгийн	255,989,000.00	122,090,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (II)	46,324,251,219.84	6,681,033,406.70
21	УРСГАЛ ЗАРДАЛ	46,324,251,219.84	6,681,033,406.70
210	БАРАА АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	21,102,359,365.96	2,744,219,652.28
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	1,121,200,896.52	1,270,052,689.39
210101	Үндсэн цалин	691,062,725.00	716,586,320.30
210102	Нэмэгдэл	187,916,952.37	235,372,221.09
210103	Унаа хоолны хөнгөлөлт	112,353,510.00	215,512,675.00
210104	Үр дүнгийн урамшуулал	129,867,709.15	102,581,473.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	142,436,784.29	163,081,093.79
210201	Тэтгэврийн даатгалын шимтгэл	97,531,780.28	115,159,238.63
210202	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	11,486,899.74	13,198,640.41
210203	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	8,973,919.91	7,062,334.71
210204	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	2,241,233.08	3,749,700.00
210205	Эрүүл мэндийн даатгалын хураамж	22,202,951.28	23,911,180.04
2103	Байр ашиглалтай холбоотой тогтмол зардал	30,231,867.07	30,464,754.65
210301	Гэрэл цахилгааны зардал	28,554,290.03	28,077,716.92
210303	Цэвэр, бохир усны зардал	-	2,387,037.73
210304	Байрны түрээс	1,677,577.04	-
2104	Хангамж, бараа материалын зардал	51,346,253.56	76,338,453.08
210401	Бичиг хэрэг	12,390,000.00	9,362,000.00
210402	Тээвэр, шатахуун	16,600,000.00	36,514,300.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	15,289,458.56	15,235,576.08
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	7,066,795.00	15,226,577.00
2105	Нормативд зардал	1,650,000.00	3,300,000.00

Нийслэлийн Өмчийн харилцааны газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,650,000.00	3,300,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	8,000,000.00	69,537,500.00
210604	Урсгал засвар	8,000,000.00	69,537,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	18,638,578,396.52	177,779,664.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр хураамж	18,620,102,200.00	144,654,718.00
210803	Даатгалын үйлчилгээ	588,060.00	534,060.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	315,912.00	315,912.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	160,000.00	130,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,849,000.00	802,000.00
210807	Газрын төлбөр	14,858,204.52	24,392,114.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	705,020.00	6,950,860.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,108,915,168.00	953,665,497.37
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,106,405,168.00	950,865,497.37
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,510,000.00	2,800,000.00
211	ХҮҮ	9,548,294,100.00	2,362,247,000.00
2112	Дотоод зээлийн үйлчилгээний төлбөр	9,548,294,100.00	2,362,247,000.00
211201	Дотоод зээлийн үйлчилгээний төлбөр	9,548,294,100.00	2,362,247,000.00
212	ТАТААС	15,528,730,069.88	-
2121	Төрийн өмчит байгууллагад олгох татаас	15,528,730,069.88	-
212101	Төрийн өмчит байгууллагад олгох татаас	12,400,000,000.00	-
212102	Нийслэлийн төсөвт төвлөрүүлсэн	3,128,730,069.88	-
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	144,867,684.00	1,574,566,753.79
2132	Бусад урсгал шилжүүлэг	62,617,709.00	56,254,262.44
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	50,847,497.30	20,592,022.44
213209	Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал	11,770,211.70	35,662,240.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	1,499,516,673.72
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	1,499,516,673.72
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	82,249,975.00	18,795,817.63
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	272,100.00	18,673,200.00
213405	Төвлөрүүлэх шилжүүлэг	81,977,875.00	122,617.63
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	8,237,567,686.00	1,935,998,505.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	8,246,193,767.50	1,957,509,897.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	8,246,193,767.50	1,957,509,897.00
2200	Дотоод эх үүсвэрээр	8,246,193,767.50	1,957,509,897.00
220001	Барилга байгууламж	132,704,550.00	26,530,692.00
223001	Бусад хөрөнгө	8,110,289,217.50	1,800,000,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	3,200,000.00	8,889,205.00
225012	Хөрөнгө оруулалтаар бэлтгэгдсэн шилжүүлэх зориулалттай хөрөнгийн зардал	-	122,090,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-8,246,193,767.50	-1,957,509,897.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-8,626,081.50	-21,511,392.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний	1,045,641,232.56	1,037,015,151.06

Нийслэлийн Өмчийн харилцааны газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

	үлдэгдэл		
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,037,015,151.06	1,015,503,759.06

2.4Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон /төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	21,484,417,253.54	11,830,828,170.68	(248,390,496,240.14)	(215,075,250,815.92)
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	(1,223,808,236.18)	(1,223,808,236.18)
C08	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	21,484,417,253.54	10,725,676,126.83	(249,614,304,476.32)	(217,404,211,095.95)
D01	2024 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	21,484,417,253.54	10,725,676,126.83	(249,614,304,476.32)	(217,404,211,095.95)
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	133,116,429,646.55	133,116,429,646.55
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	21,484,417,253.54	10,725,676,126.83	(116,497,874,829.77)	(84,287,781,449.40)
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	(390,705,746.07)	(390,705,746.07)
D09	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	21,484,417,253.54	10,725,676,126.83	(116,888,580,575.84)	(84,678,487,195.47)

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон /төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	%
I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,452,046,300.00	1,871,059,437.35	580,986,862.65	76.3
УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	2,452,046,300.00	1,871,059,437.35	580,986,862.65	76.3
Бараа, үйлчилгээний зардал	2,387,647,900.00	1,818,305,174.91	569,342,725.09	76.2
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,729,861,400.00	1,270,052,689.39	459,808,710.61	73.4
Үндсэн цалин	882,987,200.00	716,586,320.30	166,400,879.70	81.2
Нэмэгдэл	405,650,600.00	235,372,221.09	170,278,378.91	58.0
Унаа, болон бусад нөхөн олговор	325,710,000.00	215,512,675.00	110,197,325.00	66.2
Урамшуулал	115,513,600.00	102,581,473.00	12,932,127.00	88.8
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	234,357,700.00	163,081,093.79	71,276,606.21	69.6
Тэтгэврийн даатгал	159,363,300.00	115,159,238.63	44,204,061.37	72.3

Нийслэлийн Өмчийн харилцааны газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Тэтгэмжийн даатгал	18,748,600.00	13,198,640.41	5,549,959.59	70.4
ҮОМШӨ ний даатгал	14,998,900.00	7,062,334.71	7,936,565.29	47.1
Ажилгүйдлийн даатгал	3,749,700.00	3,749,700.00	0.00	100.0
Эрүүл мэндийн даатгал	37,497,200.00	23,911,180.04	13,586,019.96	63.8
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	44,090,300.00	30,464,754.65	13,625,545.35	69.1
Гэрэл цахилгаан	29,256,000.00	28,077,716.92	1,178,283.08	96.0
Цэвэр, бохир ус	5,905,900.00	2,387,037.73	3,518,862.27	40.4
Байрны түрээс	8,928,400.00	-	8,928,400.00	-
Хангамж, бараа материалын зардал	90,332,900.00	79,675,858.08	10,657,041.92	88.2
Бичиг хэрэг	9,390,000.00	9,362,000.00	28,000.00	99.7
Тээвэр (шатахуун)	37,177,500.00	36,514,300.00	663,200.00	98.2
Шуудан холбоо, интернэтийн төлбөр	16,562,400.00	15,235,576.08	1,326,823.92	92.0
Бага үнэтэй, түргэн элэгдэх, аж ахуйн эд зүйлс	27,203,000.00	18,563,982.00	8,639,018.00	68.2
Нормативт зардал	3,300,000.00	3,300,000.00	-	100.0
Нормын хувцас зөөлөн эдлэл	3,300,000.00	3,300,000.00	-	100.0
Эд хогшил худалдан авах	70,669,600.00	69,537,500.00	1,132,100.00	98.4
Урсгал засвар	70,669,600.00	69,537,500.00	1,132,100.00	98.4
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	182,341,000.00	180,275,664.00	2,065,336.00	98.9
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	145,387,400.00	144,654,718.00	732,682.00	99.5
Даатгалын үйлчилгээ	1,290,000.00	534,060.00	755,940.00	41.4
Тээврийн хэрэгслийн татвар	690,000.00	315,912.00	374,088.00	45.8
Тээврийн хэрэгслийн оношилгоо	210,000.00	130,000.00	80,000.00	61.9
Мэдээллийн технологийн зардал	3,298,000.00	3,298,000.00	0.00	100.0
Газрын төлбөр	24,465,600.00	24,392,114.00	73,486.00	99.7
Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	7,000,000.00	6,950,860.00	49,140.00	99.3
Бараа үйлчилгээний бусад зардал	32,695,000.00	21,917,615.00	10,777,385.00	67.0
Бараа үйлчилгээний бусад зардал	29,850,000.00	19,117,615.00	10,732,385.00	64.1
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,845,000.00	2,800,000.00	45,000.00	98.4
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	64,398,400.00	52,754,262.44	11,644,137.56	81.9
Бусад урсгал шилжүүлэг	64,398,400.00	52,754,262.44	11,644,137.56	81.9
Тэтгэвэрт гарахад нь олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	32,098,400.00	20,592,022.44	11,506,377.56	64.2
Нэг удаагийн тэтгэмж урамшуулал	32,300,000.00	32,162,240.00	137,760.00	99.6
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,452,046,300.00	1,871,059,237.35	580,987,062.65	76.3
ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	2,452,046,300.00	1,852,862,069.98	599,184,230.02	75.6
Орон нутгийн төсвөөс	2,452,046,300.00	1,852,862,069.98	599,184,230.02	75.6
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	-	18,197,167.37	-18,197,167.37	-
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	18,197,167.37	-18,197,167.37	-
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	200.00	(200.00)	-
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	0.00	(0.00)	-
АЖИЛЛАГСДЫН ТОО	63.00	43.00	20.00	68.3
Удирдах ажилтан	1.00	1.00	-	100.0
Гүйцэтгэх ажилтан	41.00	29.00	12.00	70.7
Үйлчлэх ажилтан	21.00	13.00	8.00	61.9

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
21	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,300,673,300.00
210	УРСГАЛ ЗАРДАЛ	3,300,550,682.37
2101	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	934,803,682.37
210101	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	934,803,682.37
210901	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	934,803,682.37
211	Хүү	2,362,247,000.00
2112	Дотоод зээлийн үйлчилгээний төлбөр	2,362,247,000.00
211201	Дотоод зээлийн үйлчилгээний төлбөр	2,362,247,000.00
	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,622,617.63
2132	Бусад урсгал шилжүүлэг	3,500,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж урамшуулал	3,500,000.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	122,617.63
213503	Төсвийн захирагчаас олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг	122,617.63
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,800,000,000.00
2200	Хөрөнгийн зардал	1,800,000,000.00
223001	Бусад хөрөнгө	1,800,000,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	5,100,673,300.00
1311	Нэмэлт санхүүжилтийн эх үүсвэр	5,100,673,300.00
131104	Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	5,100,673,300.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Нийслэлийн Өмчийн харилцааны газар нь байгууллагын зорилгоо “*Нийслэлийн өмчийг эзэмших, ашиглах, хамгаалах оновчтой бодлогыг боловсруулах, хэрэгжүүлэх замаар өмчийн үр ашиг, өгөөжийг нэмэгдүүлэх, эзэмшил, ашиглалтыг сайжруулж, эдийн засгийн чадавхыг дээшлүүлэхэд оршино.*” гэж тодорхойлжээ.

Нийслэлийн Өмчийн харилцааны газар нь 2024 онд дор дурдсан зорилтуудыг дэвшүүлсэн байна. Үүнд:

- Нийслэлийн өмчит үйлдвэрийн газрын захиралтай “Онцгой нөхцөлтэй хөдөлмөрийн гэрээ” байгуулах ажлыг зохион байгуулах, хэрэгжилтэд нь хяналт тавих, биелэлтийг дүгнэх, тухайн жилийн зорилтот түвшинг хянах, холбогдох шийдвэр гарган баталгаажуулах ажлыг зохион байгуулна;
- Нийслэлийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлэх, хэрэгжилтэд хяналт тавина;
- Нийслэлийн төсөвт байгууллагуудын удирдлагатай “Нийслэлийн өмчийг эзэмшүүлэх гэрээ”-ний хэрэгжилтийг дүгнэнэ;
- Нийслэлийн өмчийн байр талбай, эд хөрөнгийн ашиглалтыг сайжруулж, үр ашгийг дээшлүүлэх, хөрөнгийн хөдөлгөөнд хяналт тавина;
- Нийслэлийн өмчийг хувьчлах журам, Нийслэлийн Өмч хувьчлах комиссын ажиллах журмын хэрэгжилтийг ханган ажиллана;
- Ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийг хэрэгжүүлж ажиллана;
- Хяналт шинжилгээ үнэлгээ хийх төлөвлөгөө боловсруулан хэрэгжилтийг хангаж ажиллана.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Нийслэлийн Өмчийн харилцааны газрын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд тайлант онд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Нийгмийн даатгалын ерөнхий хууль;
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль /шинэчилсэн найруулга/;
- Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 82 дугаар тогтоол “Төрийн захиргааны, үйлчилгээний болон улс төрийн албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчдад орон нутгийн нэмэгдэл олгох тухай журам”.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын 6 сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Нийслэлийн Өмчийн харилцааны газрын 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын 2018 онд баталсан “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг санхүүгийн үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Нийслэлийн Өмчийн харилцааны газрын 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар баталсан “Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 507,986.6 мянган төгрөгөөр буюу 2.2 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	1,037,015.2	1,015,503.8	(21,511.4)
Авлага	1,311,178.7	1,202,957.0	(108,221.6)
Бараа материал	41,944.3	46,184.6	4,240.3
Үндсэн хөрөнгө	21,142,804.6	20,760,310.8	(382,493.9)
Нийт хөрөнгө	23,532,942.8	23,024,956.2	(507,986.6)
Өр төлбөр	240,937,153.9	107,703,443.4	(133,233,710.5)
Засгийн газрын хувь оролцоо	(217,404,211.1)	(84,678,487.2)	132,725,723.9
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	23,532,942.8	23,024,956.2	(507,986.6)

Өмнөх оны үзүүлэлтээс нөлөө бүхий өөрчлөлт гарсан нь мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөр, эздийн өмчийн данс байна.

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 1,015,503.8 мянган төгрөг болж, өмнөх оноос 21,511.4 мянган төгрөгөөр буурсан нь 6 байгууллагын 21,016.5 мянган төгрөгийн барьцаа чөлөөлж олгосонтой холбоотой.

Авлага дансны үлдэгдэл 1,202,957.0 мянган төгрөг болж өмнөх оноос 108,221.6 мянган төгрөгөөр буурсан нь хувь хүмүүсээс авах байрны түрээсийн авлага 19,755.7 мянган төгрөг, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын татаас санхүүжилтийн авлага 81,477.0 мянган төгрөгөөр тус тус барагдсантай холбоотой байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 46,184.6 мянган төгрөг болж өмнөх оноос 4,240.3 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр худалдан авсан 76,280.3 мянган төгрөг, Улаанбаатар шинэ бүтээн байгуулалт ХХК-аас шилжиж ирсэн 4,536.6 мянган төгрөг, нийт 80,816.9 мянган төгрөгөөр нэмэгдэж, зарцуулсан 63,930.9 мянган төгрөг, шилжүүлсэн 12,645.7 мянган төгрөг, нийт 76,576.6 мянган төгрөгөөр буурсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 20,760,370.8 мянган төгрөг болж өмнөх оноос 382,493.9 мянган төгрөгөөр буурсан нь төсвийн хөрөнгөөр худалдан авсан 2 нэр төрлийн 5 ширхэг 8,889.2 мянган төгрөг, Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар 67 ширхэг 286,000.0 мянган төгрөг, 3 байгууллагаас үнэ төлбөргүй хүлээн авсан 98,755.6 мянган төгрөг, 6 байгууллагаас шилжүүлэн авсан 427 ширхэг 501,428.4 мянган төгрөг, нийт 895,073.3 мянган төгрөгийн хөрөнгөөр нэмэгдэж, НӨХГ-ын шийдвэрээр 98 ширхэг акталсан 17,219.4 мянган төгрөг, “Зорчигч тээвэр нэг”, “Зорчигч тээвэр хоёр” ОНӨААТҮГ-уудад шилжүүлсэн 142,411.8 мянган төгрөг, тайлант оны хуримтлагдсан элэгдэл болох 1,117,936.0 мянган төгрөг, нийт 1,277,567.2 мянган төгрөгөөр буурсан байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 107,703,443.4 мянган төгрөг болж өмнөх оноос 133,233,710.5 мянган төгрөгөөр буурсан нь Ус сувгийн удирдах газар ОНӨААТҮГ-ын урт болон богино хугацаат өрийг Сангийн яам болон Нийслэлийн Санхүү төрийн сангийн хэлтэстэй тооцоо нийлж, зээлийн гэрээг шинэчлэн 133,116,429.6 мянган төгрөгийн өрийг бууруулах бичилт хийсэн нь нөлөөлжээ.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл -84,678,487.2 мянган төгрөг болж 132,725,723.9 мянган төгрөгөөр буурсан нь тайлант оны үр дүнгээс шалтгаалжээ.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2024 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс 2,904,553.2 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны орлогоос 178,545.6 мянган төгрөг, нийт зарлагыг 3,083,098.8 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас 840,958.8 мянган төгрөгөөр бууруулж, 2,242,140.0 мянган төгрөгөөр баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны баталсан төсвийг бүтэц орон тоог шинэчилж, орон тоог нэмэгдүүлсэнтэй холбогдуулан цалин, шимтгэлийн болон бусад зардлыг 209,906.3 мянган төгрөгөөр нэмэгдүүлж тодотгосон байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөр 2 арга хэмжээг санхүүжүүлэхээр 2,452,046.3 мянган төгрөгөөр баталжээ.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 1,871,059.4 мянган төгрөгийн санхүүжилт олгож, үндсэн үйл ажиллагааны орлого 18,673.2 мянган төгрөг, нийт 1,889,732.6

мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 1,871,059.4 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 18,673.2 мянган төгрөг буцаан төвлөрүүлсэн байна. Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,871,059.4 мянган төгрөг буюу 76.3 хувьтай байгаа нь цалин хөлсний зардлыг 459,808.7 мянган төгрөг, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 71,276.6 мянган төгрөг, байр ашиглалтын зардлыг 13,625.6 мянган төгрөг, тэтгэвэрт гарахад олгох тэтгэмжийн зардлыг 11,506.4 мянган төгрөг, бусад зардлыг 24,769.6 мянган төгрөг, нийт 580,986.9 мянган төгрөгөөр дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/					
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	70426 хөтөлбөр – Төрийн өмчийн эрхийг хэрэгжүүлэгч	2,452,046.3	1,871,059.4	580,986.9	76.3
1.1	80101 арга хэмжээ -Үндсэн үйл ажиллагааны зардал	2,387,647.9	1,818,305.1	569,342.8	76.2
1.2	80802 арга хэмжээ – урсгал шилжүүлэг, шагнал урамшуулал, буцалтгүй тусламж	64,398.4	52,754.3	11,644.1	81.9

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд нэмэлт дансаар Нийслэлийн Засаг даргын захирамжаар 5,100,673.3 мянган төгрөгийн санхүүжилт авснаас 2,362,247.0 мянган төгрөгийг “Зорчигч тээвэр гурав” ОНӨААТҮГ болон Нийслэлийн “Орон сууцны корпораци” ОНӨААТҮГ-ын зээлийн хүүгийн төлбөрт, 1,800,000.0 мянган төгрөгийг “Эмээлт эко аж үйлдвэрийн парк” ОНӨААТҮГ-ын санхүүжилтэд, 934,803.7 мянган төгрөгийг “Хот төлөвлөлт судалгааны институт” ОНӨААТҮГ санхүүжилтэд, 3,500.0 мянган төгрөгийг “Үртсэн шахмал түлшний үйлдвэр” ОНӨААТҮГ-ын нэг удаагийн буцалтгүй тусламжид тус тус захирамжийн дагуу зарцуулж, 122.6 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Нийслэлийн Өмчийн харилцааны газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг сайжруулах, анхан шатны баримтын бүрдлийг хангаж ажиллах, түрээсийн орлогыг аккрузл сууриар бүртгэх, хөрөнгийн тооллогыг чанартай зохион байгуулах нягтлан бодох бүртгэлийг тухай бүр нь үнэн зөв хөтлөхтэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг НТАГ-ын Санхүү, нийцлийн аудитын хэлтсийн аудитор Э.Ундармаа гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Д.Отгонбаяр, хэлтсийн дарга Х.Түвшинбаяр, Дэд дарга Ч.Болд нар тус тус хэрэгжүүлсэн.

Нийслэлийн Өмчийн харилцааны газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг НТАГ-т 2025 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн 1/128 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлыг тооцох эх сурвалжийг 2023 оны санхүүгийн үр дүнгийн тайланг, суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 68,734,063.4 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 687,340.6 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор тус байгууллага нь зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлыг хэмнэх арга хэмжээ авч ажилласнаар цалин хөлсний зардлыг 459,808.7 мянган төгрөг, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 71,276.6 мянган төгрөг, байр ашиглалтын зардлыг 13,625.6 мянган төгрөг, тэтгэвэрт гарахад олгох тэтгэмжийн зардлыг 11,506.4 мянган төгрөг, бусад зардлыг 24,769.6 мянган төгрөг, нийт 580,986.9 мянган төгрөгөөр батлагдсан төсвийг хэмнэсэн байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн

асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Аудитаар нийцлийн асуудлаар илэрсэн нийт 104,623.5 мянган төгрөгийн зөрчилд 2 зөвлөмж өглөө.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 25 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгахад 5 саяас дээш орлого, зарлагын гүйлгээний мөнгөн дүнг хэд салгаж эсхүл нийлүүлж, мөн түрээсийн орлого, ногдол ашиг зэргийг нэмж мэдээлсэн нь тулган баталгаажуулахад хүндрэлтэй байсан тул 2025 оны санхүүгийн тайлангийн аудитаар авч үзэхээр шийдвэрлэсэн.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

1. Төсвийн хөрөнгөөр 104,623.5 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө, бараа материал худалдан авахдаа цахим дэлгүүрээс худалдан аваагүй байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.2-т “Энэ хуулийн 37.2.4-т тодорхойлсон захиалагч ерөнхий гэрээ байгуулсан бараа, үйлчилгээг энэ хуульд өөрөөр заагаагүй бол цахим дэлгүүрээс худалдан авна.” гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын “*нийцсэн бөгөөд зохистой байх*” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Ерөнхий гэрээгээр худалдан авах нөхцөл үүсэн тохиолдолд бараа, үйлчилгээг цахим дэлгүүрээс худалдан авч байх зөвлөмж өгөв.

2. Төсвийн шууд захирагч нь тайлант жилийн бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайланг боловсруулаагүй, мэдээлээгүй байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.1-т “*Захиалагч батлагдсан төсөвт туссан төсөл, арга хэмжээ бүрээр худалдан авах ажиллагааг үр ашигтай төлөвлөж, батална.*”, Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-т “*Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ: 6.1.1 тухайн жилийн төсөв, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөлтийг жил бүрийн 01 дүгээр сарын 10-ны өдрийн дотор;*” гэж заасантай тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлагналын “*нийцсэн бөгөөд зохистой байх*” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайланг боловсруулах, хуулийн хугацаанд шилэн дансанд мэдээлэх зөвлөмж өгсөн.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн бусад хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийг бусад хууль, тогтоомжийн холбогдох заалттай зарим талаар нийцээгүй гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Шалгагдагч байгууллагын 2024 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайланд хийсэн завсрын аудитаар 1,213,334.4 мянган төгрөгийн 8 алдаа, зөрчил илрүүлж, зөрчлийг арилгах зөвлөмж өгснөөс 7 зөрчил давтан гарч, санхүүгийн тайлангийн аудитын асуудлын бүртгэлд тусгасан.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 32,452,731.6 мянган төгрөгийн 7 зөрчил илрүүлж, 46,577.0 мянган төгрөгийн 2 төлбөрийн акт, 32,396,007.1 мянган төгрөгийн 3 албан шаардлага, 10,147.5 мянган төгрөгийн 2 зөвлөмж өгснөөс 846,821.8 мянган төгрөгийн орон сууцны төлбөрийг оршин суугчдаас авч барагдуулаагүй зөрчил давтан гарсан байна.

Хүснэгт 3 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт /мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх оны үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт	2	46,577.0	2	46,577.0	100.0
Албан шаардлага	3	32,396,007.1	1	367,585.3	33.3
Зөвлөмж	2	10,147.5	2	10,147.5	100.0
Нийт дүн	7	32,452,731.6	5	424,309.8	71.4

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Шилэн дансны цахим хуудаст мэдээлбэл зохих 5.0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын гүйлгээний мөнгөн дүнг зөрүүтэй, мөн мэдээлэх шаардлагагүй түрээсийн орлого, ногдол ашиг зэргийг нэмж мэдээлсэн нь тулган баталгаажуулахад хүндрэлтэй байсан тул 2025 оны санхүүгийн тайлангийн аудитаар авч үзэхээр шийдвэрлэлээ.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналтай холбоотой нийт 84,388.9 мянган төгрөгийн 2 алдаа¹ илэрснийг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэж, баталгаажуулав. Үүнд:

- Шуудангийн 36 дугаар салбарын 28,338.9 мянган төгрөгийн 111.3 м2 талбайг санхүүгийн тайланд орхигдуулж тайлагнасан;
- 56,050.0 мянган төгрөгийн урсгал засварын ажлыг капиталжуулж тайлагнасан.

Аудитаар нийт 1,447,254.1 мянган төгрөгийн 12 зөрчил¹ илэрснээс, 100,978.2 мянган төгрөгийн 2 төлбөрийн акт тогтоож, 1,265,825.9 мянган төгрөгийн 3 албан шаардлага хүргүүлж, 80,450.0 мянган төгрөгийн 7 зөвлөмж өгсөн.

Нийт илрүүлсэн зөрчлөөс 1,447,254.1 мянган төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан тул “Хязгаарлалттай” дүгнэлт өглөө.

5.1 Төлбөрийн акт

1. Хөрөнгө оруулалтын ажил гүйцэтгэх гэрээний тусгай нөхцөлд заасан барьцааны хугацаа дууссан 97,898.6 мянган төгрөгийн барьцааг гүйцэтгэгчид буцаан олгоогүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т “*үнэн зөв байх*”, Төсвийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.7-д “*Энэ хуулийн 43 дугаар зүйлд зааснаас бусад тохиолдолд төсвийн жил дуусахад төсвийн захирагчийн төсөв зарцуулах эрх нь дуусгавар болох бөгөөд төсвийн захирагчийн төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд татан төвлөрүүлнэ*” гэж заасантай тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлагналын “*эрх ба үүрэг*”, “*нийцсэн бөгөөд зохистой байх*” батламж мэдэгдлүүдийг хангаагүй.

Шийдвэрлэсэн нь: Он удаан жил болсон хөрөнгө оруулалтын барьцааг орон нутгийн төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов.

2. Зах зээлийн үнээс хэт өндөр үнээр (*1 ширхэг шингэн вок 1,189.1 мянган төгрөг, 1 ширхэг суултуур цэвэрлэгч 1,890.5 мянган төгрөг*) цэвэрлэгээний бодисыг 3,079.6 мянган төгрөгөөр бэлтгэсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т “*төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах*”, 16 дугаар зүйлийн 16.5.5-т “*батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах*”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4-т “*хуулиар зөвшөөрөөгүй бусад*” гэж заасантай тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлагналын “*эрх ба үүрэг*”, “*оршин байх*” батламж мэдэгдлүүдийг хангаагүй.

Шийдвэрлэсэн нь: Хэт өндөр үнээр бараа материал бэлтгэсэн 3,079.6 мянган төгрөгийг орон нутгийн төсвийн орлого болгох төлбөрийн акт тогтоов.

5.2 Албан шаардлага

1. Тайлант хугацаанд 354,116.1 мянган төгрөгийн авлагыг барагдуулах арга хэмжээ авч ажиллаагүй, тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д “*эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах*”

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

ажлыг зохион байгуулах, удирдах," гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын "эрх ба үүрэг", "үнэн зөв байх" батламж мэдэгдлүүдийг хангаагүй.

Шийдвэрлэсэн нь: Авлагыг барагдуулах арга хэмжээ авч ажиллаагүй, тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй зөрчлийг зогсоож, давтан гаргахгүй байх албан шаардлага өгөв.

2.Нийслэлийн Өмчийн харилцааны газарт бүртгэлтэй "Буянт-Ухаа-1" хорооллын 28 айлын орон сууцны төлбөрийг оршин суугчдаас авч барагдуулаагүй, 851,909.8 мянган төгрөгийн авлагын үлдэгдэлтэй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1-т "Хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т "үнэн зөв байх", 20 дугаар зүйлийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасантай тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлагналын "иж бүрэн байх" болон "эрх ба үүрэг" батламж мэдэгдлүүдийг хангаагүй.

Шийдвэрлэсэн нь: Орон сууцны төлбөрийн авлагыг барагдуулах арга хэмжээ аваагүй зөрчлийг зогсоож, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

3.Хууль зүйн хэлтэстэй боловч Нийслэлийн өмчтэй холбоотой үүссэн эрүү, иргэн, захиргааны хэрэг маргааныг үнэн бодитой шийдвэрлүүлэх, байгууллагын эрх, ашиг сонирхлыг хамгаалуулах зорилгоор хуулийн фирмүүдтэй 59,800.0 мянган төгрөгийн гэрээ байгуулж ажиллахдаа төсөвт өртгийг хувааж, шууд гэрээ байгуулсан. Ажлын даалгавар тодорхойгүй, гэрээг дүгнээгүй байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3-т "Захиалагч шууд худалдан авах, харьцуулалтын аргыг хэрэглэх зорилгоор батлагдсан төсөвт өртгийг хувааж худалдан авах ажиллагаа зохион байгуулахыг хориглоно.", Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" гэж заасантай тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлагналын "эрх ба үүрэг", "үнэн зөв байх" батламж мэдэгдлүүдийг хангаагүй.

Шийдвэрлэсэн нь: Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлээгүй зөрчлийг зогсоож, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Балансын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт-1: Санхүүгийн тайланд нийт 8264 м² талбайтай 201,215.8 мянган төгрөгийн 3 газар бүртгэлтэй байна. Хур системд НӨХГ-ын эзэмшиж буй нийт 70,357 м² талбайтай 29 газрыг санхүүгийн тайланд бүртгээгүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т "үнэн зөв байх", Сангийн сайдын 2024 оны А/229 дүгээр тушаалаар баталсан Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журмын 10 дугаар бүлэгт "Үндсэн хөрөнгө" гэж заасантай тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлагналын "эрх ба үүрэг" болон "нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлүүдийг хангаагүй.

Өгсөн зөвлөмж: Байгууллагын нэр дээрх газрыг санхүүгийн тайланд бүртгэх, тайлагнах;

Илрүүлэлт-2: Санхүүгийн тайланд бүртгэлтэй 2,582,676.6 мянган төгрөгийн 7 барилга байгууламж маргаантай, холбогдох арга хэмжээ авч ажиллаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т “*үнэн зөв байх*”, Сангийн сайдын 2024 оны А/229 дүгээр тушаалаар баталсан Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журмын 10 дугаар бүлэгт “*Үндсэн хөрөнгө*” гэж заасантай тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлагналын “*эрх ба үүрэг*” болон “*нийцсэн бөгөөд зохистой байх*” батламж мэдэгдлүүдийг хангаагүй.

Өгсөн зөвлөмж: Өмчийн маргаантай барилга байгууламжийн асуудлыг шийдвэрлэх талаар арга хэмжээ авч ажиллах;

Илрүүлэлт-3: Видео танилцуулга 20,000.0 мянган төгрөгөөр хийхдээ шууд зардлаар тайлагнасан, хөрөнгийн дансанд бүртгээгүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-т “*Нягтлан бодогч нь мэргэжлийн үйл ажиллагаандаа Монгол Улсын хууль тогтоомжийг мөрдөж ажиллана*”, Зар сурталчилгааны тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-т “*Зар сурталчилгаа захиалагч, бүтээгч, түгээгч зар сурталчилгаагаар холбоотой баримт болон тэдгээрийн хуулбарыг тухайн зар сурталчилгааг сүүлчийн удаа түгээснээс хойш 6 сараас доошгүй хугацаагаар хадгална.*” гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын “*эрх ба үүрэг*” болон “*нийцсэн бөгөөд зохистой байх*” батламж мэдэгдлүүдийг хангаагүй.

Өгсөн зөвлөмж: Видео шторк, контентыг бараа материалын дансаар дамжуулан бүртгэж байх;

Илрүүлэлт-4: 2024 оны жилийн эцсийн тооллогын илтгэх хуудас, тооллогын бүртгэлээс зөрүүтэй, тооцоо бодсон актыг батлагдсан загварын дагуу бүрэн хөтлөөгүй, тооллогын комиссын дарга ахлах нягтлан бодогч, зарим гишүүд гарын үсэг зурж баталгаажуулаагүй, тооллогын үр дүнг хэлэлцэж шийдвэр гаргаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д “*эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах,*” гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын “*эрх ба үүрэг*” болон “*нийцсэн бөгөөд зохистой байх*” батламж мэдэгдлүүдийг хангаагүй.

Өгсөн зөвлөмж: Эд хөрөнгийн тооллогыг холбогдох хуулийн дагуу үр дүнтэй, чанартай зохион байгуулах;

Илрүүлэлт-5: Тайлант онд 23,830.0 мянган төгрөгийн бараа материал худалдан авахдаа бараа материалын дансаар дамжуулалгүй шууд зардлаар бүртгэсэн байна. Энэ нь Сангийн сайдын 2024 оны А/229 дүгээр тушаалаар баталсан Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журмын 8 дугаар бүлэгт “*Бараа материал 8.21*” гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын “*эрх ба үүрэг*” болон “*нийцсэн бөгөөд зохистой байх*” батламж мэдэгдлүүдийг хангаагүй.

Өгсөн зөвлөмж: Бараа материалыг орлогод авч, зарлагадаж байх;

2. Орлогын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт-6: Түрээсийн орлогыг бүртгэлд тусгаагүй, аккрузл сууриар бүртгээгүй нь нягтлан бодох бүртгэлийн зарчим алдагдаж, төсвийн орлого дутуу бүрдүүлж төвлөрүүлээгүй байх үр дагавар бий болгосон байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.5-т "*Төрийн өмчийн түрээсийн төлбөрийг улсын төсөвт оруулна*", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-т "*Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккрузл сууриар хөтөлнө*" гэж заасантай тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлагналын "*эрх ба үүрэг*" болон "*нийцсэн бөгөөд зохистой байх*" батламж мэдэгдлүүдийг хангаагүй.

Өгсөн зөвлөмж: Түрээсийн орлогыг аккрузл сууриар бүртгэх;

3. Зарлагын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт-7: Анхан шатны бүрдэл дутуу баримтаар 36,620.0 мянган төгрөгийн ажил гүйлгээ хийж, данс бүртгэлд тусгасан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.4-т "*хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх*," 13 дугаар зүйлийн 13.7-д "*Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно*." гэж заасантай тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлагналын "*эрх ба үүрэг*" болон "*иж бүрэн байх*" батламж мэдэгдлүүдийг хангаагүй.

Өгсөн зөвлөмж: Анхан шатны баримтын бүрдэл хангагдсан баримтаар гүйлгээ хийж хэвших

Дээрх зөвлөмжүүдийн биелэлтийг Нийслэл дэх Төрийн аудитын газарт 2025 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/												
Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаа-гүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шуудангийн 36 дугаар салбарын 111.3 м2 талбайг санхүүгийн тайланд бүртгээгүй.	1	28,338.9	1	28,338.9			1	28,338.9				
Урсгал засвараар хийгдсэн ажлын дүнгээр барилга байгууламжийг капиталжуулсан байна.	1	56,050.0			1	56,050.0	1	56,050.0				
Дүн	2	84,388.9	1	28,338.9	1	56,050.0	2	84,388.9				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Авлагыг барагдуулах арга хэмжээ авч ажиллаагүй, тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна.	1	354,116.1			1	354,116.1						
НӨХГ-г бүртгэлтэй "Буянт-Ухаа-1" хорооллын 30 айлын орон сууцны төлбөрийг оршин суугчдаас авч барагдуулаагүй, 28 айлаас авлагын үлдэгдэлтэй байна.	1	851,909.8			1	851,909.8						

2024 оны жилийн эцсийн тооллогын илтгэх хуудас, тооллогын бүртгэлээс зөрүүтэй, тооцоо бодсон актыг батлагдсан загварын дагуу бүрэн хөтлөөгүй, тооллогын комиссын дарга ахлах нягтлан бодогч, зарим гишүүд гарын үсэг зурж баталгаажуулаагүй, тооллогын үр дүнг хэлэлцэж шийдвэр гаргаагүй.	1	-					1	-				
Түрээсийн орлогыг бүртгэлд тусгаагүй, аккруэл сууриар бүртгээгүй нь нягтлан бодох бүртгэлийн зарчим алдагдаж, төсвийн орлого дутуу бүрдүүлж төвлөрүүлээгүй байх үр дагавар бий болгосон.	1	-					1	-				
Хөрөнгө оруулалтын ажлуудын гэрээ дүгнэсэн актад тусгагдсан чөлөөлөх хугацаа дууссан барьцааны өглөгийг төсвийн ерөнхий орлогын дансанд төвлөрүүлээгүй нь хөрөнгө оруулалтаар хийгдсэн ажлын үр өгөөж тодорхойгүй байх, төсөв дахин хуваарилалтад орохгүй байх үр дагавар үүсгэсэн.	1	97,898.6	1	97,898.6								
Санхүүгийн тайланд нийт 8264 м ² талбайтай 201,215.8 мянган төгрөгийн 3 газар бүртгэлтэй байна. Хур системд НӨХГ-ын эзэмшиж буй нийт 70357 м ² талбайтай 29 газрыг санхүүгийн тайланд бүртгээгүй байна.	1	-					1	-				
Анхан шатны бүрдэл дутуу баримтаар ажил гүйлгээ хийж, данс бүртгэлд тусгасан.	1	36,620.0					1	36,620.0				
Санхүүгийн тайланд бүртгэлтэй 2,582,676.6 мянган төгрөгийн 7 барилга байгууламж маргаантай, холбогдох арга хэмжээ авч	1	-					1	-				

ажиллаагүй.												
Видео танилцуулга хийхдээ шууд зардлаар тайлагнасан, хөрөнгийн дансанд бүртгээгүй.	1	20,000.0					1	20,000.0				
Зах зээлийн үнээс хэт өндөр үнээр цэвэрлэгээний бодис бэлтгэсэн.	1	3,079.6	1	3,079.6								
Нийслэлийн өмчтэй холбоотой үүссэн эрүү, иргэн, захиргааны хэрэг маргааныг үнэн бодитой шийдвэрлүүлэх, байгууллагын эрх, ашиг сонирхлыг хамгаалуулах зорилгоор хуулийн фирмүүдтэй гэрээ байгуулж ажиллахдаа төсөвт өртгийг хувааж, шууд гэрээ байгуулсан байна. Ажлын даалгавар тодорхойгүй, гэрээг дүгнээгүй байна.	1	59,800.0			1	59,800.0						
Бараа материал худалдан авахдаа бараа материалын дансаар дамжуулалгүй шууд зардлаар бүртгэсэн байна.	1	23,830.0					1	23,830.0				
Дүн	12	1,447,254.1	2	100,978.2	3	1,265,825.9	7	80,450.0				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Төсвийн хөрөнгөөр бараа худалдан авахдаа цахим дэлгүүрээс худалдан аваагүй байна.	1	104,623.5					1	104,623.5
Төсвийн шууд захирагч нь тайлант жилийн бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайланг боловсруулаагүй, мэдээлээгүй байна.	1	-					1	-
Дүн	2	104,623.5					2	104,623.5



НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АКТ

2025 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 27/А0270182

Улаанбаатар хот

НТАГ-2025/419/НА-СТА-ТШЗ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Нийслэлийн Өмчийн харилцааны газрын 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Хөрөнгө оруулалтын ажлуудын гэрээ дүгнэсэн актад тусгагдсан чөлөөлөх хугацаа дууссан барьцааны өглөг 97,898,551.00 (ерэн долоон сая найман зуун ерэн найман мянга таван зуун тавин нэг) төгрөгийг төсвийн ерөнхий орлогын дансанд төвлөрүүлээгүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т "үнэн зөв байх", Төсвийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.7-д "Энэ хуулийн 43 дугаар зүйлд зааснаас бусад тохиолдолд төсвийн жил дуусахад төсвийн захирагчийн төсөв зарцуулах эрх нь дуусгавар болох бөгөөд төсвийн захирагчийн төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд татан төвлөрүүлнэ" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно.", Монгол Улсын Ерөнхий аудиторов 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3.4-д "төсөвт төвлөрүүлэх ёстой татварын болон татварын бус төсвийн орлогыг төсөвт дутуу төвлөрүүлсэн эсвэл төвлөрүүлээгүй" заалтад заасныг үндэслэн **ТОГТООХ** нь:

1.Нийслэлийн Өмчийн харилцааны газар чөлөөлөх хугацаа хэтэрсэн хөрөнгө оруулалтын ажлын барьцааны үлдэгдэл 97,898,551.00 (ерэн долоон сая найман зуун ерэн найман мянга таван зуун тавин нэг) төгрөгийг Нийслэл дэх Төрийн аудитын газрын Төрийн сан банкин дахь НТАГ.хүү орлогын 100200000908 дугаар дансанд төвлөрүүлэх;

2.Актын биелэлтийг 2025 оны 05 дугаар сарын 30-ны дотор Нийслэл дэх Төрийн аудитын газарт ирүүлэхийг Нийслэлийн Өмчийн харилцааны газрын дарга В.Оюумаа, нягтлан бодогч Т.Оюунтуул нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН1:

АУДИТОР

ХЯНАСАН:

Э.УНДАРМАА

САНХҮҮ,НИЙЦЛИЙН АУДИТЫН
ХЭЛТСИЙН АУДИТЫН МЕНЕЖЕР

Д.ОТГОНБАЯР

¹ Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 4 давхар



НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АКТ

2025 оны 02 сарын 28 өдөр

Дугаар 28/А0270182

Улаанбаатар хот

НТАГ-2025/419/НА-СТА-ТШЗ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Нийслэлийн Өмчийн харилцааны газрын 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Зах зээлийн үнээс хэт өндөр үнээр (1 ширхэг шингэн вок 1,189.074 төгрөг, 1 ширхэг суултуур цэвэрлэгч 1,890.499 төгрөг) цэвэрлэгээний бодис нийт 3,079,573.00 (гурван сая далан есөн мянга таван зуун далан гурав) төгрөгөөр бэлтгэсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4-т "хуулиар зөвшөөрөөгүй бусад" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно.", Монгол Улсын Ерөнхий аудиторовн 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3.7-д "төрийн болон орон нутгийн өмч, хөрөнгийг ... хууль бусаар ашигласан" заалтад заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1.Хэт өндөр үнээр бараа бэлтгэсэн 3,079,573.00 (гурван сая далан есөн мянга таван зуун далан гурав) төгрөгийг холбогдох албан тушаалтнаар төлүүлэн Нийслэл дэх Төрийн аудитын газрын Төрийн сан банкин дахь НТАГ.хүү орлогын 100200000908 дугаар дансанд төвлөрүүлэх;

2.Актын биелэлтийг 2025 оны 05 дугаар сарын 30-ны дотор Нийслэл дэх Төрийн аудитын газарт ирүүлэхийг Нийслэлийн Өмчийн харилцааны газрын дарга В.Оюумаа, нягтлан бодогч Т.Оюунтуул нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН1:

АУДИТОР

САНХҮҮ,НИЙЦЛИЙН АУДИТЫН
ХЭЛТСИЙН АУДИТЫН МЕНЕЖЕР

ХЯНАСАН:

Э.УНДАРМАА

Д.ОТГОНБАЯР



¹ Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 4 давхар

02051182



НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 422/А0230182

Улаанбаатар хот

НТАГ-2025/419/НА-СТА-ТШЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Нийслэлийн Өмчийн харилцааны газрын 2024 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант хугацаанд 354,116,100.00 (гурван зуун тавин дөрвөн сая нэг зуун арван зургаан мянга нэг зуун) төгрөгийн авлагыг барагдуулах арга хэмжээ авч ажиллаагүй, тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах," гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.7-д "авлага, өглөгийг тооцоо нийлж баталгаажуулаагүй" заалтад заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ** нь:

1.Авлагыг барагдуулах арга хэмжээ авч ажиллаагүй, тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй зөрчлийг давтан гаргахгүй байх, биелэлтийг 2025 оны 09 дүгээр сарын 30-ны дотор Нийслэл дэх Төрийн аудитын газарт ирүүлэх;

2.Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Нийслэлийн Өмчийн харилцааны газрын дарга В.Оюумаа, нягтлан бодогч Т.Оюунтуул нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨНІ:

АУДИТОР

Э.УНДАРМАА

САНХҮҮ,НИЙЦЛИЙН АУДИТЫН
ХЭЛТСИЙН АУДИТЫН МЕНЕЖЕР

Д.ОТГОНБАЯР



¹ Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 4 давхар

02043297



НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 123/А0220182

Улаанбаатар хот

НТАГ- 2025/419/НА-СТА-ТШЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Нийслэлийн Өмчийн харилцааны газрын 2024 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Нийслэлийн Өмчийн харилцааны газарт бүртгэлтэй "Буянт-Ухаа-1" хорооллын 28 айлын орон сууцны төлбөрийг оршин суугчдаас авч барагдуулаагүй, 851,909,846.00 (найман зуун тавин нэгэн сая есөн зуун есөн мянга найман зуун дөчин зургаа) төгрөгийн авлагын үлдэгдэлтэй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1-т "Хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т "үнэн зөв байх", 20 дугаар зүйлийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.8-д "байгуулсан гэрээ, хэлцэл, холбогдох дүрэм, журмыг баримтлаагүй" заалтад заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ** нь:

1.Орон сууцны төлбөрийн авлагыг барагдуулах арга хэмжээ авч, биелэлтийг 2025 оны 09 дүгээр сарын 30-ны дотор Нийслэл дэх Төрийн аудитын газарт ирүүлэх;

2.Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Нийслэлийн Өмчийн харилцааны газрын дарга В.Оюумаа, нягтлан бодогч Т.Оюунтуул нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН1:

АУДИТОР

Э.УНДАРМАА

ХЯНАСАН:

САНХҮҮ,НИЙЦЛИЙН АУДИТЫН
ХЭЛТСИЙН АУДИТЫН МЕНЕЖЕР

Д.ОТГОНБАЯР



¹ Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 4 давхар

02043300



НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 124/А0270182

Улаанбаатар хот

НТАГ-2025/419/НА-СТА-ТШЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Нийслэлийн Өмчийн харилцааны газрын 2024 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Хууль зүйн хэлтэстэй боловч Нийслэлийн өмчтэй холбоотой үүссэн эрүү, иргэн, захиргааны хэрэг маргааныг үнэн бодитой шийдвэрлүүлэх, байгууллагын эрх, ашиг сонирхлыг хамгаалуулах зорилгоор хуулийн фирмүүдтэй 59,800,000.00 (тавин есөн сая найман зуун мянга) төгрөгийн гэрээ байгуулж ажиллахдаа төсөвт өртгийг хувааж, шууд гэрээ байгуулсан. Ажлын даалгавар тодорхойгүй, гэрээг дүгнээгүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3-т "Захиалагч шууд худалдан авах, харьцуулалтын аргыг хэрэглэх зорилгоор батлагдсан төсөвт өртгийг хувааж худалдан авах ажиллагаа зохион байгуулахыг хориглоно.", Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.9-т "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомж зөрчсөн нь энэ журмын 4.2.3-т заасан нөхцөл үүсээгүй бол," заалтад заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ** нь:

1.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомж зөрчсөн, чиг үүрэг давхардсан ажил, үйлчилгээнд төсөв зарцуулсан зөрчлийг давтан гаргахгүй байх, биелэлтийг 2025 оны 09 дүгээр сарын 30-ны дотор Нийслэл дэх Төрийн аудитын газарт ирүүлэх;

2.Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Нийслэлийн Өмчийн харилцааны газрын дарга В.Оюумаа, нягтлан бодогч Т.Оюунтуул нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН1:

АУДИТОР

Э.УНДАРМАА

САНХҮҮ,НИЙЦЛИЙН АУДИТЫН
ХЭЛТСИЙН АУДИТЫН МЕНЕЖЕР

Д.ОТГОНБАЯР

ХЯНАСАН:

¹ Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 4 давхар

2025/3/21